



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1061

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Дүгнэлт хүргүүлэх тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Шинэ нэгдсэн эвсэл"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Шинэ нэгдсэн эвсэл"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Шинэ нэгдсэн эвсэл"-ын мөрийн хөтөлбөр /...13...хуудас-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030798



МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН  
НЭГДСЭН НАМ



ШИНЭ  
НАМ




НЭГДСЭН ЭВСЭЛ

ШИНЭ НЭГДСЭН ЭВСЛИЙН  
“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ”-ИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.03.23.

## АГУУЛГА


- |    |  |      |
|----|--|------|
| 1. | ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ                               | 1    |
| 2. | МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ                    | 2    |
| 3. | МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ                          | 3    |
| 4. | МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО                           | 3    |
| 5. | МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛ                             | 3    |
| 6. | МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН УРИА                              | 4    |
| 7. | МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД<br>АШИГЛАСАН МАТЕРИАЛ | 4    |
| 8. | МӨРИЙН ХӨТӨЛБӨР                                      | 5-13 |



**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ**

- ШН
- МУНН
- ББСБ

- ШИНЭ НАМ
- МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМ
- БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА



## МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Мөрийн хөтөлбөрийн үзэл баримтлалыг гаргахдаа оюун санааны бэлэгдэл болсон тоо, тогтвортой байдлын бэлэгдэл болсон пирамид буюу гурвалжин хэлбэрээр илэрхийлж гаргалаа.

Монголчууд эрт цагаас 3, 8, 9, 81 зэрэг тооныг бэлэгшээж амьдрал ахуй, хүндэтгэлийн зан үйлд ашиглаж ирсэн түүхтэй. “3” гэсэн тоог бурханы тоо, ертөнцийн тоо хэмээн үзэж, ертөнцийн 3-ыг гурван мөрөөс тогтох бадаг бүхий шүлэглэсэн хэлбэртэй, ертөнцийн зүй тогтол, амьдралын утга учир гээд бүхий л зүйлийг багтааж үр хүүхдүүддээ цээжлүүлэн ой тогтоолтыг нь сайжруулж, оюун ухааныг нь тэлж, амьдралын ухааныг сургаж иржээ. “8” гэсэн тоогоор орчлонгийн орон зайг төлөөлүүлж найман зовхист хуваан, аж амьдрал, зан үйлдээ баримтлал болгож иржээ. “9”-ийн тоо нь “олон зүйл”, “хамаг хотол” гэсэн санааг агуулдаг. Тиймээс Монгол туургатан эрт үеэс 9-ийн тоог төрийн бэлэгдэл болгон хүндэтгэж есөн хөлт цагаан тугаа залсан байдаг. “81”-ийн тоог дээд тэнгэртэй харьцах, тэнгэр болох тохиол бүрдэх хэмээн үзэж, оюун санааны дээд тоо хэмээн үздэг байжээ.

Эвслийн бодлого, мөрийн хөтөлбөрийг тогтвортой байхыг бэлэгдэж тулгын 3 суурьтай нэгэн адил улс орны тулгуур 3 багана болох Нийгэм, Эдийн засаг, Төр гэсэн бүлэгт 9 үндсэн зорилгын дор 81 зорилтыг дэвшүүлэн мөрийн хөтөлбөрөө болголоо.



(Зураг №1. Мөрийн хөтөлбөрийн үзэл баримтлалын загварчлал)





## ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, бүх нийтийн сайн сайхныг цогцлоохын тулд энэхүү мөрийн хөтөлбөрийг Эрхэм сонгогч Танд танилцуулж байна.

Аз жаргалтай гэр бүлээс Нийгэм эдийн засгийн зохистой харилцаа бүхий ардчилсан, эрх зүйт төрийг байгуулах хүчирхэг Монгол иргэн төрнө.

## ЗОРИЛГО

Улс үндэстний оршин тогтнолын тулгуур 3 бүрдэл болох Нийгэм, Эдийн засаг, Улс төр тус бүрийг тэнцвэржүүлж, Хүчирхэг Монгол улсыг дахин бүтээнэ.

Үүний тулд дараахи 3 зорилгыг дэвшүүлж байна

1. Нийгмийн шинэ бодлого хэрэгжүүлж, Ард түмний эрүүл мэндийг хамгаалж; Боловсролын тогтолцоог сайжруулж; Амьдралын чанарыг нэмэгдүүлнэ;
2. Хөгжлийн шинэ эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, Төсөв санхүүгийн эргэлтийг нэмэгдүүлж; Бизнес ээлтэй эдийн засгийг цогцлоож; Аж үйлдвэржилтийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ;
3. Төрийн шинэ бодлого хэрэгжүүлж, Хууль тогтоох засаглалыг хариуцлагажуулж; Гүйцэтгэх засаглалыг чадавхижуулж; Шүүх засаглалыг хүчирхэгжүүлнэ;

## ЗОРИЛТ

Тулгуур бүрдэл	Зорилго	Зорилт буюу мөрийн хөтөлбөр
Нийгэм буюу ард түмэн	Нийгмийн эрүүл мэндийг хамгаална	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт
	Боловсролын тогтолцоог сайжруулна	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт
	Амьдралын чанарыг нэмэгдүүлнэ	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт
Эдийн засаг	Төсөв, санхүүгийн эргэлтийг нэмэгдүүлнэ	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт
	Бизнес ээлтэй эдийн засгийг цогцлооно	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт
	Аж үйлдвэржилтийг дэмжинэ	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт
Улс төр	Хууль тогтоох засаглалыг хариуцлагажуулна	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт
	Гүйцэтгэх засаглалыг чадавхижуулна	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт
	Шүүх засаглалыг хүчирхэгжүүлнэ	Зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт

Бид 9 зорилгын хүрээнд 81 зорилт буюу мөрийн хөтөлбөр боловсруулан гаргалаа.




## МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН УРИА

### НЭГДМЭЛ МОНГОЛ УЛСЫН ДАХИН БҮТЭЭЭ

## МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Мөрийн хөтөлбөрөө боловсруулан гаргахдаа дараах бодлогын болон эрх зүйн баримт бичигт нийцүүлэн гаргалаа. Үүнд:


1. Монгол улсын Урт хугацааны хөгжлийн баримт бичиг болох “АЛСЫН ХАРАА 2050”
2. Тогтвортой хөгжлийн бодлого 2030
3. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр
6. Шинэ намын 2020 оны мөрийн хөтөлбөр
7. Шинэ намын 250 мянган гишүүдийн төлөөлөл
8. Эрдэмтэн судлаачдын санал, зөвлөмж



# 1. НИЙГМИЙН ШИНЭ БОДЛОГО

## 1.1. Эрүүл мэндийн шинэ бодлого


- 1.1.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, чадавхийг сайжруулах замаар иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.2. Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын хөтөлбөрт эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх агуулгыг тусгаж, эрүүл амьдралын зан үйлийг төлөвшүүлнэ.
- 1.1.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж, хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхи бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ.
- 1.1.4. Эрүүл мэндийн салбарын цахим үйлчилгээ, техник технологийг сайжруулснаар эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, хяналтыг дээшлүүлж, иргэн бүрийн эрүүл мэндийн мэдээллийн санг бий болгох, иргэд эрүүл мэндийн үйлчилгээгээ өөрөө хянах боломжийг бүрдүүлэхэд чиглэж ажиллана.
- 1.1.5. Оношлогоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологи бүхий олон улсын жишигт нийцсэн тусламж үйлчилгээг иргэд бүс нутагтаа авах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.1.6. Бүх нийтийн биеийн тамирыг амьдралын нэг хэсэг болгосноор халдварт бус өвчин, түүнээс шалтгаалсан нас баралтыг бууруулж, эрүүл идэвхитэй амьдралын зөв хэв маягтай Монгол хүнийг төлөвшүүлнэ.
- 1.1.7. Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үед эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлнэ.
- 1.1.8. Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, Монгол анагаах ухааныг олон улсад бренд болгон хөгжүүлнэ.
- 1.1.9. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоог сайжруулж, эрүүл мэндийн байгууллагын хараат бус, бие даасан удирдлагыг дэмжиж, хувийн болон улсын даатгалын хосолсон тогтолцоог хөгжүүлэх замаар эрүүл мэндийн даатгалын санг нэмэгдүүлж, даатгалаа төлсөн иргэн үр шимээ хүртэх боломжийг нэмэгдүүлнэ.





## 1.2. Боловсролын шинэ бодлого

- 1.2.1. Боловсролын салбарын засаглал, удирдлагын тогтолцоог тогтвортой тасралтгүй хөгжүүлнэ.
- 1.2.2. Сургуулийн өмнөх болон бага боловсрол нь хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, хүүхдийн хүмүүжил, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг бий болгоно.
- 1.2.3. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулгыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн, шилдэг менежментийг нэвтрүүлнэ.
- 1.2.4. Төрийн болон хувийн хэвшлийн сургуулийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг ижил түвшинд хүргэж, ялгаатай байдлыг арилгана.
- 1.2.5. Багшийн ажлын бүтээмжийг сайжруулах, хүүхэд бүрт хүрч ажиллах боломжийг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломж, карьер өсөх менежментийн тогтолцоог бүрдүүлэх бодлого баримтална.
- 1.2.6. Аймаг орон нутаг дахь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их дээд сургуулиуд, сургалт эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолборыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хөгжүүлнэ.
- 1.2.7. Боловсролын зээлийн сангийн мэдээллийн ил тод, нээлттэй байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.2.8. Иргэн бүр орон зай цаг хугацаанаас үл хамааран, нас насандаа тохирсон мэдлэгийг авах эрх зүйн орчныг сайжруулна.
- 1.2.9. Эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны үндсэн чиглэлийг тогтоож, үр дүн гүйцэтгэлд суурилсан, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх судалгааны лабораторийн менежмент, зохион байгуулалтын эрх зүйн шинэ орчинг бүрдүүлнэ.



### 1.3. Амьдралын чанарыг сайжруулах шинэ бодлого


- 1.3.1. Гэр бүлийн амьдралын чанарыг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.3.2. Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын тогтолцоог бэхжүүлэн тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, аюулгүй байдлыг хангана.
- 1.3.3. Эцэг эхчүүдийн ажлын цагийг оновчтой сонголттой болгож, ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангаж, гэр бүлд ээлтэй орчин нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.3.4. Тэтгэвэрт гарагсдын тоог урьдчилан харж, хувь хүн болон төрийн зүгээс ахмад настануудын тэтгэврийн орлогыг бүрдүүлэх зорилгоор хуримтлал бий болгох эрх зүйн орчныг сайжруулна.
- 1.3.5. Монгол улсын иргэн бүр эх орондоо эрүүл, аятай тухтай амьдарч, аюулгүй орчинд ус агаар, хүнсний аюулгүй байдалд санаа зовохгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.3.6. Хүнсний хангамж, нийлүүлэлтийн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагаар дамжуулан үндэсний баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой тогтолцоог бий болгоно.
- 1.3.7. Стандартын ногоон байгууламж, цэцэрлэгт орчныг тэлэх замаар ногоон бүс, цэцэрлэгт хүрээлэн байгуулах бодлогыг дэмжинэ.
- 1.3.8. Суурин газар, гэр хорооллыг мэргэжлийн байгууллагын удирдлага дор иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон амины болон орон сууцны цогц хороолол байгуулах бодлогыг дэмжинэ.
- 1.3.9. Агаарын чанар, хог хаягдал, хөрсний бохирдлын асуудалд онцгой анхаарч, 1 хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулна.



## 2. ХӨГЖЛИЙН ШИНЭ ЭДИЙН ЗАСАГ

### 2.1. Эдийн засаг, Төсөв, Санхүүгийн шинэ бодлого

- 2.1.1. Улсын нэгдсэн төсвийг алдагдалгүй, үр ашигтай, хяналттай байх тогтолцоог бэхжүүлнэ. Төрийн менежментийг сайжруулах замаар нэгдсэн төсвийн урсгал зардлыг бууруулна.
- 2.1.2. Төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого зохицуулалтыг сайжруулж, татварын бодлогыг оновчтой болгож, төсвийн орлогын бааз суурийг бэхжүүлнэ.
- 2.1.3. Дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдөх эх үүсвэр ашиглаж, өрийн багц дахь хувьсах хүүтэй гадаад зээлийг ашигтай нөхцөлд тогтмол хүүтэй зээлд шилжүүлж Монгол улсын зээлжих зэрэглэлийг сайжруулна.
- 2.1.4. Банк болон бусад санхүүгийн салбарын чөлөөт өрсөлдөөнийг сайжруулж, хэрэглэгчдэд сонгох боломжийг нэмэгдүүлснээр зээлийн хүүг бууруулах бодлого баримтална.
- 2.1.5. Тэтгэврийн сан, тэтгэврийн даатгалын сангийн хуримтлалыг өсгөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.1.6. Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.
- 2.1.7. Стратегийн ач холбогдол бүхий томоохон төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох бодлогыг дэмжинэ.
- 2.1.8. Эдийн засгийн тулгуур үзүүлэлтүүдийг сайжруулснаар инфляцийн түвшинтэй уялдуулж, бодлогын хүүг зохих түвшинд хүргэж, валютын нөөцийг тасралтгүй нэмэгдүүлнэ.
- 2.1.9. Банкны тогтолцоон дахь өмчлөлийн болон удирдлагын төвлөрлийг задлан нээлттэй болгох замаар олон нийтийн хяналтыг бэхжүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.



## **2.2. Бизнесийг дэмжих шинэ бодлого**

- 2.2.1. Дундаж давхрагыг тэлж бэхжүүлэн, эрсдэлээс хамгаалж, орлого багатай иргэн өрхийг дундаж давхаргад оруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 2.2.2. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, ажлын байр нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 2.2.3. Өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес хөгжих эрх зүйн орчныг сайжруулах бодлого баримтална.
- 2.2.4. Жижиг дунд бизнесийн орон нутгийн хөгжилд үзүүлэх эдийн засгийн үүргийг нэмэгдүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
- 2.2.5. Монгол брендийн эко, органик, био, натурал хүнс боловсруулах салбарыг хөгжүүлж, гадаадад экспортлохыг дэмжинэ.
- 2.2.6. Үндэсний агуулгатай инноваци шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 2.2.7. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн дотоод гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 2.2.8. Монголын нүүдлийн соёл иргэншлийн өвийг баяжуулан хөгжүүлж, дэлхийд соёл урлагийн бүтээл туурвин таниулж, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.2.9. Баялагийн сангийн эрх зүйн орчинг сайржуулж, уул уурхайгаас бусад бүхий л бизнесийн салбарын хөгжлийг бодлогоор дэмжинэ.

## **2.3. Аж үйлдвэржилтийн шинэ бодлого**

- 2.3.1. Өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологи ашиглаж, экспортод чиглэсэн, харьцангуй давуу тал дээр тулгуурласан үйлдвэрлэл хөгжүүлнэ.
- 2.3.2. Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа, эрдэс баялагийн нэгдсэн мэдээллийн санг баяжуулах эрх зүйн орчныг сайжруулна.
- 2.3.3. Уул уурхайн эрдэс, түүхий эдэд түшиглэсэн зэсийн баяжмал, газрын тос боловсруулах, нефьт хими, кокс хими, металлургийн нүүрс угаах болон нүүрс



хими, нүүрс эрчим хүч, метан хими, ган төмөрлөгийн, жонш баяжуулах, алт цэвэршүүлэх зэрэг өндөр технологийн хүнд үйлдвэрийн цогцолборууд хөгжих бодлого баримтална.

2.3.4. Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

2.3.5. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.3.6. Хиймэл оюун ухаан, үүлэн технологи, тооцоолол, орчин үеийн дизайн програмчлал, процесс загварчлал, нано болон пико, био технологи, квант тооцоолол зэрэгт суурилсан аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

2.3.7. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах ногоон үйлдвэрлэлийн төслүүдийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.3.8. Хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлийн салбаруудыг олон улсын стандартад нийцүүлэх замаар үйлдвэржүүлэх бодлогын дамжлагат уялдаатай байдлыг бий болгож, бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцүүлэн хөгжүүлнэ.

2.3.9. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн удирдлагын болон ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлж, технолгийн дэвшил, инновацийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах бодлого баримтална.





### 3. ТӨРИЙН ШИНЭ БОДЛОГО

#### 3.1. Хууль тогтоох засаглал

- 3.1.1. Ард түмний засаглах эрхийг хангасан, итгэл хүлээсэн хууль тогтоох байгууллагыг төлөвшүүлнэ.
- 3.1.2. Улсын их хурлын гишүүнд тавих ёс зүйн асуудлыг өндөрт тавьж, намууд сонгуульд нэр дэвшигчдээ тодруулахдаа ёс зүй, сахилга хариуцлагын үндсэн шаардлага дээр гишүүд дэмжигчдээр нээлттэй хэлэлцүүлдэг болгоно.
- 3.1.3. Хууль тогтоох үйл явц нотолгоо, судалгаанд суурилсан тогтолцоог бэхжүүлж, иргэдэд ил тод нээлттэй хэлэлцүүлэх өрнөсөн цахим парламентын эрх зүйн орчныг сайжруулна.
- 3.1.4. Улсын их хурлын хууль тогтоох үйл ажиллагааг төгөлдөржүүлж, түүний чанар үр нөлөөг дээшлүүлнэ.
- 3.1.5. Улсын их хурлын хянан шалгах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж, хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөөг үнэлэх байнгын тогтолцоог бүрдүүлж чадавхижуулна.
- 3.1.6. Улсын их хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, парламентад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлнэ.
- 3.1.7. Улсын их хурлын гадаад харилцааг өргөжүүлж, парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- 3.1.8. Улсын их хурлын гишүүдийн ёс зүйн зөрчил гаргасан, гэмт хэрэгт холбогдсон үйлдэлд хариуцлага тооцож бүрэн эрхийг түдгэлзүүлж, эргүүлэн татдаг байх эрх зүйн орчныг сайжруулна.
- 3.1.9. Улсын их хурлын гишүүд тойрогтоо төсөв хуваарилдаг байдлыг таслан зогсоож, нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчмыг баримталж ажиллана.

#### 3.2. Гүйцэтгэх засаглал

- 3.2.1. Гүйцэтгэх засаглалаар дамжуулан иргэний болон улс төрийн эрх, эрх чөлөө, эдийн засаг, нийгэм соёлын эрх, хөгжих эрх зэрэг жам ёсны эрхүүдийг бэхжүүлнэ.



- 3.2.2. Эрх мэдлийн хуваарилалт, хяналт тэнцлийг оновчтой болгож, Гүйцэтгэх засаглалын тогтвортой байдлыг хангана.
- 3.2.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд талуудын оролцоог хангах эрх зүйн орчныг сайжруулна.
- 3.2.4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төгөлдөржүүлэх бодлогыг тусгана.
- 3.2.5. Төрийн албан хаагчийн мерит зарчмыг баримтлан хууль бусаар ажлаас халах, албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр мэргэжлийн бус хүнийг томилох асуудлыг таслан зогсооно.
- 3.2.6. Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.
- 3.2.7. Гүйцэтгэх засаглалын үндсэн үүргүүдийн нэг болох авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг сайжруулж, шударга ёсны тогтолцоог бэхжүүлнэ.
- 3.2.8. Авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгоно.
- 3.2.9. Төрийн байгууллагуудын “Шилэн дансны тухайн хууль”-ийн хэрэгжилтийн хангах зорилгоор шилэн дансны нэгдсэн системийг улам боловсронгуй, нээлттэй, ил тод болгох эрх зүйн орчныг сайжруулна.

### 3.3. Шүүх засаглал

- 3.3.1. Шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх засаглалтай эрх мэдлийн хувьд нэгэн адил, бие даасан байх байдлыг бэхжүүлнэ.
- 3.3.2. Шүүх нь хараат бус байдлыг хангах зорилгоор бодлогоо өөрсдөө боловсруулдаг тогтолцоог бий болгохын төлөө ажиллана.
- 3.3.3. Шүүх нь төсвөө өөрсдөө боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэн батлуулдаг эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлнэ.



- 3.3.4. Шүүгч нарыг томилох буюу сонгох, дэвшүүлэх журам нь ил тод, нээлттэй, тодорхой байлгах эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлнэ.
- 3.3.5. Шүүгчийг мэдлэг, туршлага, ёс зүйн чанарыг бодитоор үнэлсний үндсэн дээр нэр дэвшүүлж, томилдог эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.
- 3.3.6. Шүүгч нарыг авлигаас ангид байлгах эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.
- 3.3.7. Шүүгчид сахилгын арга хэмжээ ногдуулах буюу огцруулах ажиллагааг чангатгах эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.
- 3.3.8. Авлигаас ангид, шударга, ёс зүйтэй ажиллаж байгаа шүүгчийг бүх насаар нь томилон ажиллуулдаг эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.
- 3.3.9. Шүүх засаглалын нийгэм дэх нэр хүнд, иргэдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх замаар шударга ёсыг бэхжүүлднэ.

